

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Оюу Толгойн Хяналт ТББ нь уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин ба хүний нийгэмд учрах нөлөөллийг МУ-ын хууль, олон улсын байгаль орчин ба хүний эрхийн гэрээ конвенцийн эрх зүйн норм, олон улсын санхүүжүүдэгч байгууллагуудын хамгааллын бодлогын стандартад нийцүүлж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах нөлөөллийн үйл ажиллагаа, эрх нь хөндөгдсөн талуудын эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах судалгаа, сургалт явуулах, үндэсний, гадаадын болон олон улсын байгууллагуудын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Оюу Толгойн Хяналт ТББ нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд Олон улсын хөгжлийн банкуудын санхүүжилтийг хянах сүлжээ байгууллагууд, түүнчлэн байгаль орчин, хүний эрхийг хамгаалагчдын дуу хоолой болсон үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг.

Манай байгууллага **Төслийн ажилтан** шалгаруулж авна.

Үндсэн чиглэл

- Байгаль орчин ба хүний эрх

Гүйцэтгэх үндсэн үүрэг

- Төсөл хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаа
- Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ба хэрэгжүүлэх
- Үр дүнг хянах ба тайлагнах
- Төсөл хэрэгжүүлэхэд хамаарах гадаад ба дотоодын түншүүдтэй харилцах
- Төслийн төсвийн зарцуулалтыг анхан шатны тайлагнал
- Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын бусад ажил үүрэг
- Хөдөө орон нутагт томилолтоор ажиллах

Ажлын байранд тавигдах шаардлага

- Бакалавр болон түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй
- Төслийн менежментийн туршлагатай
- Бичиг боловсруулах өндөр чадвартай
- Англи хэлний мэдлэгтэй
- Компьютерийн хэрэглээний програмууд дээр чөлөөтэй ажиллах чадвартай

Нэмэлт мэдээлэл

- Хариуцлагатай, хариуцлага хүлээх чадвартай
- Идэвх санаачлагатай, бүтээлч сэтгэлгээтэй
- Харилцааны соёлтой, хувийн зохион байгуулалт сайтай
- Багаар болон бие даан ажиллах чадвартай
- Нас харгалзахгүй

Бусад

Төрөл Бүтэн цагийн

Цалин Тохиролцоно